



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/329

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит бус XII хуралдааны 02 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн өргөдөл, хүсэлт, суманд ажиллаж байгаа ажлын хэсгийн дүгнэлт, сумын Засаг даргын саналыг харгалзан согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох жагсаалтыг 1 дүгээр, сунгах жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр), Цагдаагийн газар (Цагдаагийн дэд хурандаа Т.Ганхуяг), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан журмыг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10 дугаар захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл оролцогчид мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.


5. Тусгай зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийг аймгийн орон нутгийн орлогод төвлөрүүлж, тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 09  
дүгээр сарын 29-ны өдрийн А/329  
дугаар захирамжийн 1 дүгээр  
хавсралт




СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн		Нэр, байршил	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Оршин суугаа хаяг	Иргэн, аж ахуй нэгжийн нэр		
1	Галт сум 5-р баг	“Хишигван” ХХК РД4131207	“Миний дэлгүүр” Хүнсний дэлгүүр Галт сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	Галт сум 3-р баг	Дагтар Пүрэвдорж РД88062951	“Дүүрэн” Супермаркет Галт сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	Цагааннуур сумын 1-р баг	Халзанхүү Нямбаяр РЦ79041571	“Номин” Хүнсний дэлгүүр Цагааннуур сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

---oOo---

Аймгийн Засаг даргын 2022 оны 09  
дугээр сарын 29-ны өдрийн А/З.29  
дугаар захирамжийн 2 дугаар  
хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАСАН ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн		Нэр, байршил	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Оршин суугаа хаяг	Иргэн, аж ахуй нэгжийн нэр		
1	Жаргалант сумын 1-р баг	Магсаржав Энхболд PE79050371	"Тээл" Хүнсний дэлгүүр Жаргалант сумын 5-р багт	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	Цагаан-Уул сумын 6-р баг	Жигжидсүрэн Батболд РП79112210	"Богд" Хүнсний дэлгүүр Цагаан-Уул сумын 6-р багт	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	Цагааннуур сумын 1-р баг	Дамдинсүрэн Отгон- Оюун РИ69051008	"Цахлай-2" Хүнсний дэлгүүр Цагааннуур сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

---oOo---